



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур”-ыг хоёрдугаар, “Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т даалгасугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зохих төсвөөс тус тус санхүүжүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

4. Энэ журмыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Чинзориг/-т даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/184 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201215

## **Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусадтай адил нийгмийн амьдралд тэгш, бие даан оролцох боломжийг олгоход оршино.

1.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан бие даан амьдрах эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх)-нд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулахад иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага (цаашид “үйлчилгээ үзүүлэгч” гэх) болон хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хоорондын харилцааг тус журмаар зохицуулна.

1.3.Хувийн туслах үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан 18 ба түүнээс дээш насны хүн (цаашид “үйлчилгээ авагч” гэх) тус тус хамрагдана.

### **Хоёр.Үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг хянан шийдвэрлэх**

2.1.Үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэн тус журмын 3-т заасан баримт бичгийг бүрдүүлж, өөрийн оршин сууж буй нутаг дэвсгэрийн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өгнө.

2.2.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж, нэг сард авах үйлчилгээний цагийг тодорхойлсон дүгнэлт гаргана.

2.3.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан хүний бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

2.4.Байнгын асаргаа шаардлагатай хүн өөрөө хүсэлт гаргах боломжгүй тохиолдолд түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргаж болно.

2.5.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын 2.3-т заасны дагуу Амьжиргааг дэмжих зөвлөлийн гаргасан шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногт багтаан аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.6.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.5-д заасан шийдвэр, баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан хянаж, үйлчилгээнд

хамрагдах иргэнд хувийн хэрэг нээн баталгаажуулж, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ.

2.7.Үйлчилгээнд хамрагдах иргэн нийгмийн халамжийн бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээнд хамрагдаж байгаа тохиолдолд энэ журмын 3-т заасан баримт бичгийг давхардуулан шаардахгүй.

2.8.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн тухай хүсэлт гаргасан иргэнд мэдэгдэж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаар танилцуулж, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна.

### **Гурав.Үйлчилгээнд хамрагдах иргэний бүрдүүлэх баримт бичиг**

3.1.Үйлчилгээнд хамрагдах иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.1.1.үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл;

3.1.2.иргэний үнэмлэхний хуулбар;

3.1.3.эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар.

### **Дөрөв.Үйлчилгээний төрөл, зохион байгуулалт**

4.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу бие даан амьдрах үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

4.1.1.хувийн туслах үйлчилгээ;

4.1.2.зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан үйлчилгээг зохион байгуулах сургалтын жишиг хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

4.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг тус хуулийн 18.6 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д зааснаар сонгон шалгаруулах ажлыг энэ журмын 2.3-т заасны дагуу сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.

### **Тав.Санхүүжилт**

5.1.Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх болон Хувийн туслах үйлчилгээний хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт тохирсон хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэхээс бусад зардлыг Нийгмийн халамжийн сангаас, Хувийн туслах үйлчилгээний хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт тохирсон хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус тус санхүүжүүлнэ.

5.2.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.6 дахь хэсэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлэх гэрчилгээтэй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

5.3.Гэрээг байгуулахдаа нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан гэрээний загварыг баримтална.

5.4.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхэд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг нийгмийн халамжийн үйлчилгээний төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталсан аргачлал, заавраар тооцож санхүүжилтийг олгоно.

5.5.Хувийн туслах үйлчилгээний зардлын нэг цагийн үнийн дүнгийн 10 хувийг үйлчлүүлэгч хувь хүн өөрөө төлнө.

5.6.Үйлчилгээ үзүүлэгч нь улирал тутам үйл ажиллагааны, сар бүр санхүүгийн тайлан, холбогдох баримтын хамт бүрдүүлэн сар бүрийн 25-ны дотор аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

5.7.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гэрээгээр гүйцэтгэж буй үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг дараа сарын 10-ны дотор үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлнэ.

## **Зургаа.Бусад**

6.1.Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина.

6.2.Хуурамчаар баримт бичиг үйлдсэн иргэн болон үйлчилгээнд хамрагдах иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг хуурамчаар үйлдсэн, нийгмийн халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг хууль зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага нь дараах тохиолдолд үйлчилгээг зогсооно.

6.3.1.үйлчилгээнд хамрагдаж буй иргэн нас барсан;

6.3.2.хуурамч материал бүрдүүлэн үйлчилгээнд хамрагдсан нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

6.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг амжилттай хэрэгжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулна.

6.5.Үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдээллийн сан бий болгон, холбогдох мэдээ тайлан, судалгааг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын нэгдүгээр хавсралт

**Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах үйлчилгээнд хамруулах нөхцөл байдлын үнэлгээ**

**1. Ерөнхий мэдээлэл**

1. Таны оршин суугаа газар

Аймаг, хот ..... Сум, дүүрэг .....

2. Таны нас

1. 16-18
2. 19-23
3. 24-29
4. 30-35
5. 36-41
6. 42-47
7. 48-53
8. 54 ба түүнээс дээш

3. Таны боловсролын түвшин

1. Боловсролгүй
2. Бага
3. Бүрэн бус дунд
4. Бүрэн дунд
5. Тусгай дунд
6. Дээд

4. Сууцны эзэмшлийн хэлбэр

1. Өөрийн эзэмшлийн хашаа байшин
2. Өөрийн эзэмшлийн хашаа гэр
3. Өөрийн эзэмшлийн орон сууц
4. Эцэг эхийн хашаа байшин /гэр/
5. Нийтийн байр
6. Түрээсийн өрөө
7. Түрээсийн орон сууц
8. Түрээсийн гэр байшин
9. Өөр .....

5. Та хөгжлийн бэрхшээлийн аль төрөлд нь багтдаг вэ?

1. Сонсголын бэрхшээлтэй
2. Хэл ярианы бэрхшээлтэй
3. Харааны бэрхшээлтэй
4. Хөдөлгөөний бэрхшээлтэй
5. Сэтгэцийн бэрхшээлтэй
6. Оюун ухааны хомсдолтой
7. Хавсарсан

6. Таны энэ бэрхшээл

1. Төрөлхийн
2. Олдмол

7. Таны ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал

1. Төрийн байгууллага
2. Хувийн байгууллага
3. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
4. Төрийн бус байгууллага
5. Оюутан/сурагч
6. Ажилгүй
7. Тэтгэвэрт/групп
8. Бусад .....

8. Ямар төрлийн тэтгэвэр авдаг вэ?

1. Халамж
2. Тэжээгчээ алдсаны
3. Бусад
4. Авдаггүй

9. Ам бүлийн тоо /..... /

10. Та хэн хэнтэйгээ хамт амьдардаг вэ?

1. Эхнэр/Нөхөртэйгээ
2. Эхнэр/Нөхөр хүүхэдтэйгээ
3. Хүүхэдтэйгээ
4. Ах, эгч, дүү нартайгаа
5. Төрсөн эцэг эхтэйгээ
6. Хадам эцэг эхтэйгээ
7. Хамаатан садантайгаа
8. Асран хамгаалагчтайгаа
9. Асрамжийн газарт
10. Ганцаараа

11. Танай ам бүлд тогтмол ажил хийдэг хэдэн хүн байгаа вэ?

1. Нэг хүн
2. Хоёр хүн
3. Гурван хүн
4. 4 ба түүнээс дээш хүн ажил хийдэг
5. Ажил хийдэг хүн байхгүй

12. Танай өрхийн сарын орлого

1. 100,000 төгрөгөөс доош
2. 100,000-200,000
3. 200,000-300,000
4. 300,000-400,000
5. 400,000-500,000
6. 500,000-700,000
7. 700,000-1,000,000
8. 1,000,000-1,500,000
9. 1,500,000-2,000,000
10. 2,000,000 ба түүнээс дээш

13. Танай өрхийн орлогын хүрэлцээ?

1. Өдөр тутмын ойр зуурын /хоол, унд гэх мэт/ хэрэгцээнд ч хүрэлцдэггүй
2. Өдөр тутмын хэрэгцээнд л хүрэлцдэг, илүү гардаггүй
3. Дээрхээс гадна зайлшгүй шаардлагатай /хувцас хунар гэх мэт/ зүйлс авч чаддаг, мөнгө хүрэлцдэг, гэхдээ үнэтэй зүйл авахад нилээд хугацаагаар
4. Хуримтлуулах шаардлага гардаг
5. Мөнгө хангалттай, хүссэн зүйлээ авч чаддаг

14. Таны хувьд оршин суугаа нутаг орон /хот, дүүрэг, аймаг, сум/ тань хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад хэр таатай орчин гэж боддог вэ?

1. Амьдрахад таатай
2. Дунд зэрэг
3. Тааламжгүй

**2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг сард авах  
үйлчилгээний цагийг тогтоох аргачлал**

Д/д	Асуулга	Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Эрсдэлтэй үед дэмжлэг авдаг (2 оноо)	Хэсэгчилэн дэмжлэг авдаг (3 оноо)	Бүрэн дэмжлэг хэрэгтэй (5 оноо)
1	Хөрвөөх				
2	Орноосоо өндийх				
3	Тэнцвэрээ хадгалж суух				
4	Шилжих үйлдэл /орноосоо сандал, тэргэнцэр рүү/				
5	Хөл дээрээ зогсох				
6	Алхаж чадах				
7	Хувцас өмсөх				
8	Шилжих үйлдэл /тэргэнцэрээс 00 руу/				
9	Шилжих үйлдэл /тэргэнцэрээс ванн руу/				
10	Биеэ угаах				
11	Бие засах /хөнгөнөөр/				
12	Бие засах /хүндээр/				
13	Шүд угаах				
14	Хоол хийх				
15	Хоол идэх				
16	Гэр цэвэрлэх				
17	Гэрийн цахилгаан хэрэгсэл ашиглаж чадах чадвар				
18	Өдөр тутмын амьдралдаа шийдвэр гаргах				
19	Мөнгө захиран зарцуулах чадвар				
20	Эмийг ялган таних, жорын дагуу зөв хэрэглэх, гэрийн нөхцөлд эмчилгээг хэрхэн хийх талаар тайлбарлах				
21	Эрүүл мэндийн байдлаа бусдад тайлбарлан хэлэх				
22	Эрсдэлтэй байдлыг тодорхойлох				




23	Худалдааны байгууллагаар үйлчлүүлэх				
24	Тээврийн хэрэгслээр зорчих				
25	Гадуур гарах				
26	Өргөдөл бичих, баримт бичгийн асуудлыг хариуцах				
27	Монгол дохионы хэлнээс аман болон бичгийн хэлний хооронд орчуулга хийх				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	1 м зайд байгаа зүйлийг баримжаалж чаддаг (1 оноо)	Бараг харахгүй (3 оноо)	Огт харахгүй (6 оноо)
28	Харах чадвар				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Жирийн дуу авиаг сонсоно (1 оноо)	Бараг сонсохгүй (3 оноо)	Огт сонсохгүй (6 оноо)
29	Сонсох чадвар				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Тусгай ойлголцдог хүн байвал харилцаж чадна (1оноо)	Ярилцахаас өөр аргаар харилцдаг (3 оноо)	Огт ярьж, харилцаж чадахгүй (6 оноо)
30	Ярих, харилцах чадвар				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Хэсэгчилсэн дэмжлэг хэрэгтэй (1 оноо)	Заримдаа дэмжлэг хэрэгтэй (3 оноо)	Бүрэн дэмжлэг хэрэгтэй (6 оноо)
31	Унших, бичих				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Онцлог үед дэмжлэг хэрэгтэй (3 оноо)	Бүрэн дэмжлэг хэрэгтэй (6 оноо)	
32	Орчиндоо төөрөх				
Асуулга		Дэмжлэг хэрэггүй (0 оноо)	Онцлог үед дэмжлэг хэрэгтэй (3 оноо)	Бүрэн дэмжлэг хэрэгтэй (6 оноо)	
33	Сэтгэцийн хямралд оромтгой				

Асуулга		Тийм (1-6 оноо)		Үгүй (0 оноо)	
34	Цооролттой				
35	Стомын уут, шээсний уут хэрэглэдэг				
36	Катьетр				
37	Диализийн аппаратанд ордог эсэх				
38	Клизм хэрэглэдэг эсэх				
39	Булчингийн чангаралтай эсэх				
Асуулга		Хаус (0 оноо)	Орон сууц (1 оноо)	Байшин (3 оноо)	Гэр (6 оноо)
40	Амьдарч буй орчин				
Асуулга		Хүртээм жтэй (0 оноо)	Ихэнхдээ хүртээмжтэй (1 оноо)	Бага зэрэг хүртээмжтэй (3 оноо)	Хүртээмжгүй (6 оноо)
41	Амьдарч буй орчны хүртээмж				
42	Ариун цэврийн хэрэглэлээ солих чадвар				
43	Живхээ солих чадвар				
44	Өөрт хамааралтай мэдээ, мэдээллийг авах				
45	Гар утас хэрэглэх чадварт сургах				
46	Шилжих үйлдэл /тэргэнцэрээс авто машин руу/				
47	Хувцас угаах, индүүдэх				
48	Үс угаах				
49	Газар унасан эд зүйлсээ авах				
50	Өтгөн шингэнээ хянах				
51	Газраас 1.5м өндөрт байгаа зүйлийг авах				
52	Ажлын байран дээрх дэмжлэг				
	Нийт оноо				

Тайлбар:

1. Асуулгын хариултанд тохирох хэсэгт тэмдэглэгээ хийж бөглөнө. Нэг сард авах хувийн туслах үйлчилгээний дээд хязгаар 150 цаг байна.
2. Үнэлгээний асуулгын 1 оноог 1 цаг гэж үзэн үйлчилгээний цагийг тогтоох бөгөөд нийлбэр оноогоор тухайн хүнд нэг сард үзүүлэх цагийн хэмжээг тогтооно.
3. Ерөнхий мэдээллийн асуулга нь оноонд тооцогдохгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын хоёрдугаар хавсралт



**БИЕ ДААН АМЬДРАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД  
ХАМРАГДСАН ИРГЭНИЙ ХУВИЙН ХЭРЭГ**

№

.....Аймаг, дүүрэг

.....сум, хороо

Овог..... Нэр.....

Төрсөн он сар өдөр ..... Нас..... Хүйс .....

Регистрийн дугаар .....

Эхэлсэн он сар өдөр .....

Дуусах он сар өдөр.....

Хаяг: 1 .....

2 .....

Хувийн хэрэг нээсэн: ..... Аймаг, дүүргийн ..... сум,

хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний гарын үсэг ..... / .....

Хянаж баталсан: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга ..... / .....

..... он сар .... өдөр

### ХУВИЙН ХЭРЭГТ ХАВСАРГАСАН МАТЕРИАЛ

Д/д	Бүрдүүлсэн материал	Тэмдэглэл
1	Үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл	
2	Иргэний үнэмлэхийн хуулбар	
3	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар	
4	Шаардлагатай холбогдох материалыг хавсаргах	

### БИЕ ДААН АМЬДРАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Д/д	Он	Хамрагдсан үйлчилгээний төрөл	Дүгнэлт /ахиц дэвшил/	Хэдэн онд, ямар байгууллагад, хэдэн цагийн ямар үйлчилгээ авсан
1				
2				
3				
4				
5				
6				

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын 2021 оны 11 дугаар сарын  
25-ны өдрийн А/1.1.8.7 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

## Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх болон холбогдох байгууллагаас үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний зөвшөөрөл олгох, хяналт үнэлгээ хийх, магадлан итгэмжлэхэд энэ шалгуурыг ашиглана.

### Хоёр.Үйлчилгээний төрөл

2.1.Хувийн туслах нь дараах үйлчилгээг үзүүлнэ.

2.1.1.олон нийт, нийгмийн харилцааны арга хэмжээний хүрээнд:

2.1.1.1.олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс хамааран биечлэн болон цахим хэлбэрээр дэмжлэг үзүүлэх;

2.1.1.2.дэлгүүр, худалдаа, банк зэрэг үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авахад нь тусламж дэмжлэг үзүүлэх;

2.1.1.3.эрүүл мэндийн үйлчилгээ авах, эм тариаг эмчийн зааврын дагуу хэрэглэхэд нь туслахын дэмжлэг үзүүлэх;

2.1.1.4.хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт тохирсон хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.2.мэдээллийн хүртээмжийн хүрээнд:

2.1.2.1.ном, сонин сэтгүүл уншиж өгөх, мэдээллийн хэрэгцээг хангах;

2.1.2.2.сонсголгүй иргэдэд үзүүлэх дохионы хэлний хэлмэрчийн дэмжлэг үзүүлэх;

2.1.3.ахуйн хүрээнд:

2.1.3.1.агаар салхинд гарах;

2.1.3.2.хоол цай хийх, хооллох;

2.1.3.3.усанд оруулах;

2.1.3.4.цагаан хэрэглэл, хувцсыг нь угааж индүүдэх, солих;

2.1.3.5.бие засахад туслах;

2.1.3.6.хэвтрийн өвчтөнийг сэлгүүлж хэвтүүлэх, ор дэвсгэрийг засч өгөх;

2.1.3.7.ус, түлш, хүнс бэлтгэх, цэвэрлэгээ хийх.

### **Гурав.Үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэнд тавигдах шаардлага**

**3.1.Үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага дараах шаардлагыг хангасан байна.**

3.1.1.нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан байх;

3.1.2.үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ авагч хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн болон туршлагатай хүний нөөцтэй байх;

3.1.3.байгууллагын дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх заавартай байх;

3.1.4.сургалтын жишиг хөтөлбөрийг үндэслэн үйл ажиллагааны онцлогийг тусгасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

3.1.5.үйлчилгээ авагчийн санал хүсэлт, шаардлагыг хангах, эрэлт, хэрэгцээг үнэлэх аргачлал, үнэлгээний хуудастай байх;

3.1.6.үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйлчилгээг хэрэгжүүлэх ажилтантай гэрээ байгуулсны үндсэн дээр үйлчилгээг үзүүлэх;

3.1.7.үйлчилгээ авагч болон үйлчилгээ үзүүлэх ажилтны гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байх;

3.1.8.үйлчилгээ үзүүлэгчийг мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор эрх бүхий байгууллагын сургалтад жилд нэгээс доошгүй удаа хамруулсан байх;

3.1.9.шашны номлол, улс төрийн үзэл, бодлогыг албадан тулгахгүй, аль нэгэн нам эвсэл, шашныг сурталчилсан нөхцөл байдал бүрдүүлэхгүй байх;

3.1.10.архи, мансууруулах бодис тогтмол хэрэглэдэг, гаж зуршилтай, халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх.

### **3.2.Үйлчилгээ үзүүлэх иргэнд тавигдах шаардлага**

3.2.1.үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ авагчийн хүсэл, сонирхол, хараат бус бие даасан байдал, сонголт, нэр төрийг нь хүндэтгэн үзэх, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй байна.

3.2.2.үйлчилгээ үзүүлэгч нь ёс зүйн өндөр хариуцлага, хувийн ашиг сонирхолгүй байна.

3.2.3.үйлчилгээ үзүүлэгч нь хувийн туслах бэлтгэх сургалтад хамрагдаж ур чадвар эзэмшсэн байна.

3.2.4.үйлчилгээ үзүүлэгч нь хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, ажиллах арга зүйн ерөнхий мэдлэгтэй байна.

3.2.5.үйлчилгээ үзүүлэгч нь анхны тусламж үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах туршлагатай байна.

3.2.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллахад тулгарах эрсдэл, шинэ хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, шийдвэрлэх, даван туулах чадвартай байна.

3.2.7. хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон харилцааны ур чадвартай байна. /сонгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах дохионы хэлний харилцааны ур чадвар/.

3.2.8. үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үндсэн дээр ажиллах бөгөөд байнгын болон цагийн ажилтан байж болно.

3.2.9. үйлчилгээ үзүүлэгч нь өдөрт нэг ба түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж болно.

3.2.10. үйлчилгээ үзүүлэгчийн ажлын цагийн хуваарь нь уян хатан байх ба өдөрт 8 хүртэл цаг ажиллаж болно.

### **3.3. Үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна.**

3.3.1. үйлчилгээ авагчийн эрхийг дээдлэн, эрх тэгш, хүндэтгэлтэй хандаж, ялгаварлан гадуурхахгүй байх;

3.3.2. үйлчилгээ авагчтай тус шалгуурын 2.1-д заасан үйлчилгээний төрлөөс зөвшилцсөний үндсэн дээр бие даан сонголтоо хийх боломжийг олгосон байх;

3.3.3. хүчирхийллийн аливаа хэлбэр, гадуурхал, үл хайхрах байдлаас ангид үйлчилгээг аюулгүй орчинд үзүүлдэг байх;

3.3.4. үйлчилгээ нь чанартай, сэтгэлд нийцсэн тухайн үйлчилгээ авагчийн асуудлыг шийдвэрлэсэн байх;

3.3.5. үйлчилгээ үзүүлэгч нь эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамрагдах ба халдварт өвчин, эмгэггүй, муу зуршилгүй байх.

### **Дөрөв. Үйлчилгээний хяналт, үнэлгээ**

4.1. Үйлчилгээ авагчийн гарын үсгээр баталгаажсан үйлчилгээ үзүүлэгчийн харилцаа, хандлага, ур чадварын талаарх өдөр тутмын тэмдэглэл хөтөлсөн байна.

4.2. Сургалтад хамрагдсан иргэдийн амьдралын чанарт гарсан өөрчлөлтийн талаар үнэлгээ хийж, баримт бичиг, мэдээллийг тайланд хавсаргасан байна.

4.3. Үйлчилгээ авагчийн амьдралын чанарт гарсан өөрчлөлт болон үйлчилгээний талаар үнэлгээ хийж, баримт бичиг, мэдээллийг тайланд хавсаргасан байна.

4.4. Байгалийн гамшиг болон онцгой байдлын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөтэй, түүний дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.5. Үйлчилгээг чанаргүй гүйцэтгэсэн, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироосон тохиолдолд сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэрээг зогсоох тухай эрх бүхий байгууллагад санал хүргүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

4.6. Энэхүү үйлчилгээний хэрэгжилтэд аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

## Тав.Бусад

5.1.Гэрээ байгуулж үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэн, хуулийн этгээд тайлан мэдээ, баримт бичгийг хуурамчаар бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр тайлагнасан бол гэм буруутай этгээдийн гэрээг цуцлах болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Үйлчилгээ үзүүлэгч нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4-т заасан тэтгэмжид давхар хамрагдахгүй аль нэг үйлчилгээг сонгоно.

\_\_оОо\_\_



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын 2021 оны 11 дугаар сарын  
28 -ны өдрийн 11.18 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

## **Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан хүнд тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу амьдралын итгэл, үнэмшил бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх болон холбогдох байгууллагаас үйлчилгээний чанарыг сайжруулах, зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэхэд энэ шалгуурыг ашиглана.

### **Хоёр.Үйлчилгээний чиглэл**

2.1.Энэхүү үйлчилгээ нь үйлчилгээ авагчийн тулгамдсан асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, мэдлэг хуримтлуулах, хөгжин дэвших, харилцан итгэлцэлд суурилсан дадал, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын үйл ажиллагаа юм.

2.2.Амьдралын итгэл үнэмшил бий болгох, бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулна. Үүнд:

2.2.1.эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, өөдрөг хандлага ба амьдралыг үзэх үзэл, үнэлэмжээ дээшлүүлэх, харилцаа хандлага, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд өөрийгөө зөв илэрхийлж, бусадтай харилцах чадвар олгох сургалт;

2.2.2.өдөр тутмын үйлдэл хийхэд шаардлагатай ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл зэргийг ашиглах сургалт;

2.2.3.өдөр тутмын харилцаанд орох дохионы хэлний анхан шатны сургалт;

2.2.4.цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалт;

2.3.Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих сургалт зохион байгуулна. Үүнд:

2.3.1.гар урлал, сүлжмэл эдлэл, модон эдлэл, бэлэг дурсгал, оёдол, компьютерийн хэрэглээний болон цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт;

2.3.2.санхүүгийн болон бизнес эрхлэх суурь мэдлэг олгох, хуримтлал үүсгэх, өрхийн төсөв хөтөлж сурахад чиглэсэн сургалт;

2.3.3.мэргэшсэн ур чадвартай хүний туршлага, мэдлэгийг хуваалцах уулзалт, ярилцлага зохион байгуулах;

2.4.Хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, тулгамдсан асуудал, бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах зөвлөгөө, мэдээлэл өгнө. Үүнд:

- 2.4.1.нийгмийн үйлчилгээний төрлөөр зөвлөгөө өгөх үйлчилгээ;
- 2.4.2.эдийн засаг, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ;
- 2.4.3.сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ;
- 2.4.4.хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ;
- 2.4.5.хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ.

### **Гурав.Үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага**

3.1.Үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1.нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан байх;

3.1.2.өөрийн өмчийн болон түрээсийн байртай байх;

3.1.3.байгууллагын дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх заавартай байх;

3.1.4.мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

3.1.5.ажилтан бүр ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх;

3.1.6.байгууллагын зорилго, зорилт, бүтэц, ажилтны талаарх мэдээлэл болон сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэр, төрлийг нээлттэй байршуулсан байх;

3.1.7.сургалтын жишиг хөтөлбөрийг үндэслэн үйл ажиллагааны онцлогийг тусгасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

3.1.8.сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, дадлага хийх орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.1.9.үйлчилгээ авагчийн талаар түүний зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, нийтлэл тараахгүй байх;

3.1.10.байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байх;

3.1.11.үйлчилгээ авагчийн гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэл, мэдээлэлтэй байх;

3.1.12.улс төрийн аль нэгэн нам эвсэл, шашныг сурталчилсан нөхцөл байдал бүрдүүлэхгүй байх;

3.1.13.архи, мансууруулах бодис тогтмол хэрэглэдэг, гаж зуршилтай, халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх.

## **Дөрөв.Үйлчилгээ үзүүлэх ажилтанд тавих шаардлага**

- 4.1.Үйлчилгээ үзүүлэх ажилтан нь тухайн сургалт, зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн байх;
- 4.2.Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 4.3.Үйлчилгээ авагчтай харилцан зөвшилцөж чаддаг, тэдний зан үйл, бэрхшээлийн хэлбэрт тохируулан тэднийг дэмжин сурган хүмүүжүүлэх ур чадварыг эзэмшсэн, харилцааны соёлтой байх;
- 4.5.Мэдээллийн технологийн ололт амжилтыг эрэлхийлэн, үйлчлүүлэгчдийн онцлог хэрэгцээнд тохируулан практикт хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх;
- 4.6.Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах дохионы хэлний харилцааны ур чадвартай байх;
- 4.7.Зөвлөн туслах, ойлгуулан таниулах, багаар ажиллах чадвартай байх;
- 4.8.Үйлчилгээ авагчийн өөрийнх нь давуу талыг мэдрүүлж, суралцах, өөрийгөө удирдах, хөгжүүлэх аргыг зааж сургах чадвартай байх;
- 4.9.Үйлчилгээ авагчийн мэдээлэл, үйлчилгээний үр дүн, өөрчлөлтийн талаар тэмдэглэл хөтөлсөн байх;
- 4.10.Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх сургалт зохион байгуулах чиглэлээр эрх бүхий байгууллагын сургалтад жилд нэгээс доошгүй удаа хамрагдсан байх.

## **Тав.Үйлчилгээнд тавих шаардлага**

- 5.1.Үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэн, хувийн шинж чанарыг хүндэтгэн үзэж, ялгаварлан гадуурхахгүй байх;
- 5.2.Үйлчилгээний зорилго, агуулга, арга зүй нь үйлчлүүлэгчдийн эрэлт, онцлог хэрэгцээг хангахад чиглэсэн, ажил, мэргэжлийн болон хувь хүний хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц агуулгатай байх;
- 5.3.Үйлчилгээ үзүүлэх анги танхим, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт сургалтын орчныг бүрдүүлсэн байх;
- 5.4.Үйлчлүүлэгчдэд сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээний хөтөлбөр, аргачлал, холбогдох журмыг танилцуулах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, хэрхэн тусалж, зөвлөж болох талаар мэдээлэл өгч ажиллах;
- 5.5.Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 5.6.Үйлчлүүлэгчдээс сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдахаас өмнө болон хамрагдсаны дараах мэдлэг чадварын түвшинг тогтоосон сорил, сэтгэл ханамжийн судалгаа авсан байх;
- 5.7.Үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх, холбогдох мэдлээллийг мэдээллийн санд нэгтгэн оруулах, тайлан мэдээ гаргах;
- 5.8.Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, шаардлагыг хангах, эрэлт хэрэгцээг үнэлэх аргачлалтай байх;
- 5.9.Үйлчлүүлэгчид өгч буй зөвлөгөө нь үнэн зөв, бодитой, тухайн үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байх;

5.10.Нийтлэг асуудлаар зөвлөгөө өгөх тохиолдолд бүлгийн зохион байгуулалтад оруулж хамтаар нь зөвлөгөө өгч болох бөгөөд 20-иос илүүгүй хүн байх;

5.11.Хууль, журамд заагаагүй болон гэрээнд тусгагдаагүй ажил үйлчилгээг үзүүлэхгүй байх.

### **Зургаа.Ажлын байр, орчны эрүүл ахуйн шаардлага**

6.1.Хот, сууринд байгаа бол төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамжинд холбогдсон, цахим харилцаа холбоотой байх;

6.2.Сургалт зохион байгуулах өрөө нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхаас гадна шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж бүхий орчныг бүрдүүлсэн байх;

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлсэн байх;

6.4.Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байх;

6.5.Байгалийн гамшиг болон онцгой байдлын үед ажиллах яаралтай тусламжийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй, түүний дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

6.6. Галын аюулгүй байдлын самбар, гал унтраах хэрэгслээр хангагдсан байх.

### **Долоо.Үйлчилгээг үнэлэх**

7.1.Үйлчилгээг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

7.1.1.үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл, гомдол, түүнийг хэрхэн барагдуулсан талаарх бүртгэл, ирцийн тэмдэглэл;

7.1.2.үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, давтамж, сэтгэл ханамжийн судалгааны дүн, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

7.1.3.сургалтад хамрагдсан иргэдийн амьдралын чанарт гарсан өөрчлөлтийн талаар үнэлгээ хийж, баримт бичиг, мэдээллийг тайланд хавсаргасан байна.

7.2.Энэхүү үйлчилгээний хэрэгжилтэд сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага болон хөндлөнгийн байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

7.3.Үйлчилгээ үзүүлэгч нь тайлан мэдээ, баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн болон тайлагнасан тохиолдолд гэрээг цуцлах, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.